



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

□ “Бэрэн майнинг” ХК-ийн үнэт цаасыг нийтэд □
санал болгохыг зөвшөөрсөн үнэт
цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тогтоолоор бүртгэсэн “Бэрэн майнинг” ХК-ийн гаргасан нэг бүр нь 157.35 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,740,813,320 /нэг тэрбум долоон зуун дөчин сая найман зуун арван гурван мянган гурван зуун хорь/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Ц.Цэрэндаш/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН